

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Хорих ял эдлүүлэх ажиллагаа

ХОРИГДЛЫН ЭРХИЙГ ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ

HISTORICAL ASPECTS OF LEGAL REGULATION OF ENSURING RIGHTS OF PRISONERS



Б.Галбадрах

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч,
доктор (Ph.D), хошууч*

Товч утга: Хоригдлууд бусад иргэдийн адил дээр дурдсан эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан эрхүүд олгогдсон байдаг. Хоригдлын эрх зүйн байдлыг гол онцлог нь тэдний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлаж хорих байгууллагын төрлөөс хамаарч тусгай эрх, үүрэг оногдуулдагт оршдог юм.

Түлхүүр үгс: хорих ял, хоригдол, түүхэн баримт.

Abstract: Prisoners, like other citizens, are entitled to the same rights set out in the aforementioned legal documents. The main feature of the legal status of prisoners is that their rights and freedoms are limited to a certain extent and special rights and obligations are assigned depending on the type of prison.

Keywords: imprisonment, prisoner, panopticon.

Дэлхийн түүхэнд төрт ёс үүсэн буй болсон эртний цаг үеэс эхлэн улс гүрэн, овог аймгийн доторх хууль цаазыг батлан мөрдүүлэхийн зэрэгцээ нийтийн эрх ашиг, сонирхлын эсрэг аливаа үйлдлийг хориглон хуульчилж, зөрчсөн этгээдэд ял шийтгэл оногдуулах явдал уламжлагдан хөгжиж ирсэн билээ. Улмаар үүнтэй зэрэгцэн ял цээрлэлийг хэрэгжүүлдэг буюу эдлүүлдэг чиг үүрэг бүхий бүтэц, хариуцах алба, төрийн байгууллагын анхны хэлбэр бий болсон бөгөөд хөгжлийн эн тэнцүү үе шатыг даван туулж ирсэн гэж үздэг.

хэв заншлаас үүдэн тухайн үеийн ялын бодлогын хувьд хорих ял нь тийм их өргөн хэрэглэгдэж байгаагүй юм².

Тухайн үед монгол хоригдол бусад улсын хоригдлын эрх зүйн байдал мөн ялгамжтай байсан. Академич Ч.Далай “Орой бүрий, үүрийн харанхуйгаар хятад хүний хөл хорино”, “Хятад хүн анх удаа хэрэг хийвэл зүүн мөр дээр, хоёр дахь удаад баруун мөрөн дээр, гурав дахь удаад хүзүүн дээр шивээс тавина”, “Хятад хүн шоронд орвол хоол хүнсээ өөрөө хариуцна” гэх мэт хятад хүнийг гадуурхан үзсэн заалт цөөнгүй байсан. Харин “Монгол хүн шоронд орвол улсаас хоолломой” гэх мэтээр хятадуудаас давуу эрхтэй байхаар хуульчлагдсан байсан³.

Их Юань гүрний дараагийн хууль тогтоомж болох Алтан хааны цаазын бичиг, Арван буянт номын цааз, Хутугтай Сэцэн хун тайжийн шашны бичиг, Халхын цааз эрхэмжийн бичиг зэрэг түүхэн эрх зүйн баримт бичгүүдэд хорих ялын талаар дурдаагүй байна. Харин 1640 оны Монгол-Ойрдын цаазын бичигт газар нүхэнд хорих ялын төрлийг тусган хэрэглэж байсан байна.

Хорих ял нь нүүдэлчин хэв маягтай хүмүүсийн хувьд амьдралын хэв маягт төдийлөн тохирдоггүй байсан учир тийм ч их хэрэгждэггүй байсан⁴. 1640 оны Монгол-Ойрдын цаазын бичигт газар нүхэнд хорих ялын төрлийг тусгаж хэрэглэж байсан байна.

И.Дашням “Ши-цзи”-д арав хоногоос илүү хугацаагаар хорихгүй, улс даяар хоригдол хүн хэдхэнээс хэтрэхгүй гэж дурдсан нь ял эдлүүлэх талаар төрөөс тогтоосон хэм хэмжээний гол агуулгыг илэрхийлж байна. Удаан хугацаагаар хорих бодит шаардлага нүүдлийн соёр иргэншилтэй улс оронд төдий л байхгүй байсантай холбоотой. Нүүдэллэн амьдрах хэв маяг нь суурьшмал шорон гяндан барих, гэмт хэрэгт сэжиглэгчдийг удаан хугацаагаар байцаах, хорих явдлыг хязгаарлахад байсан гэж тэмдэглэсэн⁵. Үүнээс харахад тухайн үеийн хууль тогтоогчид хорих ял, цаашлаад хоригдлын эрх зүйн байдлын асуудлыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг олж хараагүй байна.

Их Монгол Улс бутран унаж, XVII зуунд Монголд Манжийн ноёрхлын үе ирсэн байдаг. Үүнийг даган Манжийн нөлөө дор тэдний эрүүгийн эрх зүйн үзэл хандлагыг шингээсэн Халх журам, Монгол цаазын бичиг, Гадаад Монголын төрийн засах явдлын яамны хууль зүйлийн бичиг зэрэг баримт бичгүүд батлагдсан⁶. Өмнө нь хэрэгжиж байсан цааз бичгүүдэд хэрэглэгдэж байгаагүй, монголчуудын амьдралын хэв маягт нийцээгүй ял буюу хорих ялыг оногдуулахаар хуульчилсан байна. Энэ үед манжийн хууль тогтоомжийн нөлөө дор Монголд

² Дугарова С.Ж. Характеристика уголовно-правовых запретов Великой Ясы // Хууль сахиулахуй. 2016. № 2. 57 дахь тал.

³ Ч.Далай. Юан гүрний үеийн Монгол. Уб., 1973. 76 дахь тал.

⁴ Рязановский В.А. Дурдсан бүтээл. 55 дахь тал.

⁵ Дашням И. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. Тэргүүн боть. Уб., 2005. 59 дэх тал.

⁶ Рязановский В.А. Дурдсан бүтээл. 88 дахь тал.

тусгаар тогтнолоо харийн эрхшээлээс чөлөөлөх түүхэн цаг үе тулж ирсэн юм. Тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцлийн төлөөх уйгагүй хичээл зүтгэлийн үр дүнд 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр одоогийн Улаанбаатар хот буюу Их хүрээнд VIII Богд Жавзандамба хутагтыг тулгар улсын хаанд өргөмжилж, Засгийн газрыг шинээр байгуулан дэлхий нийтэд зарлан тунхаглажээ.

1914 онд Хуучин цагийн гянданг шинэчлэн барих ажил өрнөж эхэлснийг түүхэн баримтад дурдсан байна. Тухайлбал, гяндангийн байр хуучирч муудсаны дээр ялт хүмүүс багталцахгүй, шээх баах газар байхгүйгээс үүдэн ялт хүмүүсийн үнэр үлэмж муу байх тул өөр уужим байшин, хашаа үйлдүүлж хорих талаар Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яамны сайд Эрдэнэ Далай гүн ван Гомбосүрэн Богд эзэн гэгээнд толилуулсан байдаг.

Тус асуудлыг Богд хааны зарлиг ёсоор болгож, “Гянданг гадаад улсын янзтай үйлдэгтүн” хэмээснээр сангийн яамнаас 1 түм 700 мянга 300 цаасыг хуваарилан олгохоор тогтсон байна.

Шүүх яамны гянданг гадаад орны адилаар үйлдүүлэхийн тулд Жуй Юван Гүй, Шин И Лүн, Ван И Лүн хэмээх 3 пүүсээр хийлгэхээр тогтсон бөгөөд дараах гяндан, хорих байрыг барьж байгуулжээ. Үүнд:

- Төв өмнөдөд 5 өрөөтэй урт нь 5 хос алд, өндөр нь 1 хос алд 2 тохой, тоосго туургатай, шавардсан, орос их цонх 4, бага цонх 4, өмнө, хойно банзан хаалга, чулуун довжоотой, 2 ямх банз дэвсгэр шалтай, шургаагаар дээвэр тавьж, шавардсан байшин 1 /үүнд сахих дарга, хуяг нар сууна/;

- Төв дунд хүнд ялтныг хорихоор үйлдсэн урт нь 5 хос алд, өргөн нь 2 хос алд, өндөр нь 1 хос алд, 3 тохой бүхий 10 өрөөтэй, өрөө тутам сараалжтай, төмөрлөсөн давхар их хаалгатай Их гяндан 1, нижгээд цонхтой, төмөрлөсөн их хаалга, модон дээвэр тавьж, шавардсан гяндан;

- Хойдод өндөр нь 1 хос алд, 2 тохой, урт нь 5 хос алд, өргөн нь 2 хос алд, 8 ямхын дөрвөлжин модон туургатай, 6 өрөөтэй, цонх нижгээд, 3 ямхын банз дэвсгэр шалтай, төмөрлөсөн их хаалгатай, модон дээвэр тавьж шавардсан гяндан 1;

- Зүүн, баруун этгээдэд хөнгөн ялтныг хорихоор үйлдсэн өндөр 1 хос алд 1 тохой, өргөн нь 3 хос алд, урт нь 3 хос алд, 3 өрөөтэй, төмөр сараалжтай, доторх өрөөнд бага хаалга нижгээд гяндан 1;

- Зүүн, баруун, хойд зовхист ялт ардыг шээлгэх баалгах зэрэгт бэлтгэж үйлдсэн шавардсан байшин зэргийг байгуулжээ.

Түүнчлэн “Гяндан”-ийн гадуурх нь 2 хос алд битүү шургаагаар шорон үзүүртэй хашаа байгуулж, түүний гадуур нь хос алдын шургаагаар давхар хашаа барьж, өмнөдөөр тус тус нижгээд хаалгатай хашаа үйлдүүлсэн байна.

Түүхэн баримтаас үзвэл 1914 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр барилгын ажлыг дуусган Богд эзэн гэгээнд айлтгасан байна.

хугацааг эдэлсний дараа мөн календарийн жилд 14 хоногийн чөлөө олгодог байсан. Харин бусад ангийн ба ажлын ангийн боловч онц хүнд гэмт явдлыг үйлдсэн жишээлбэл: үлэмжхэн юм зэргийг ашиглах зэргээр сүйтгэсэн ба албан тушаалын хуваарь мөн хүнд хэргийг үйлдсэн хүмүүст уг ялын хугацаанаас 1 жил 6 сараас доош бусыг эдэлсний дараа календарийн жилд 7 хоногийн чөлөө, 3 жил ба дээш ялыг эдэлсний дараа мөн календарийн жилд 14 хоногийн чөлөө олгох боломжтой байсан байна (55-р зүйл). Мөн тухайн хуулиар хоригдогсод гадагш захидал илгээх хүлээн авах эрхтэй байсан хэдий ч аливаа захидлуудыг харьяат засан сайжруулах газрын даргаар уламжлуулж тухай бүрд түүнээс үзэж танилцах зохицуулалттай байсан.

Доктор (Ph.D) А.Лхагва Улсын Бага Хурлаас 1931 онд батлан гаргасан Монгол Ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хуулийн зарим нэр томъёо (колони, хянах комисс, ангийн шинж чанартай заалтууд гэх мэт), бүлэг, зүйлийн нэр зэрэг нь ЗСБНХОУ-ын 1924 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуультай адил төсөөтэй заалт байдаг боловч агуулгын хувьд жинхэнэ монгол маягийн хууль байсан байжээ гэж үзсэн¹⁶.

Социалист үзэл санааны нөлөө дор 1966 онд БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль батлагдсан¹⁷. Тухай хуулийн боловсруулалтад НҮБ-аас баталсан Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм (1955 он), БНМАУ-ын Үндсэн хуулийг шинэчлэн баталсан (1960 он) болон БНМАУ-ын НҮБ-д элссэн үйл явдлууд нь түлхэц болсон бөгөөд эрх зүйн орчинд орсон өөрчлөлтийг дагаад шинээр батлагдсан хуулиудын зарчимд нийцсэн Засан хүмүүжүүлэх ажиллагааг зохицуулсан хуулийг шинэчлэх хэрэгцээ үүссэн гэж үзэж болох юм. 1931 оны Монгол Ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хуультай харьцуулахад 1966 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль нь хоригдлын эрх зүйн байдлын хувьд маш их өөрчлөлт орсон. Хоригдлын эрхийн талаар тусгайлсан зүйлийг хуульчилсан.

Тус хуулиар хоригдлын эрхийн тогтолцоо бүрдсэн байна. Тухалбал, хоол, хувцас болон бусад материалын хангамжийг тогтоосон нормоор хэрэглэх (19-р зүйлийн 1 дэх хэсэг); хийсэн хөдөлмөрийн тоо, чанарт тохирсон шимтгэлийг тогтоосон журмаар авах (19-р зүйлийн 2 дахь хэсэг); гэр бүл, ойрын төрөл садантайгаа биечлэн уулзах, захидлаар харилцах, илгээлт, эргэлтийн зүйлийг хүлээн авах (19-р зүйлийн 3 дахь хэсэг); колонийн тэг гортиг доторхи дэлгүүр, мухлагаас зөвшөөрөгдсөн хэрэгцээт зүйлээ тогтоосон хэмжээнд багтаан тооцоогоор авах (19-р зүйлийн 4 дэх хэсэг); тогтоосон журмаар ном хэвлэл захиалж ашиглах (19-р зүйлийн 5 дахь хэсэг); өргөдөл, гомдлыг аль ч байгууллага, албан тушаалтанд колонийн захиргаагаар дамжуулан гаргах (19-р зүйлийн 6 дахь

¹⁶ А.Лхагва, М.Гахүү. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Уб., 2015. 21 дэх тал

¹⁷ А.Лхагва Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эрх сурвалж, Уб., 2013. 43-45 дахь тал.

нарийн чанд сахиулах ажилд БНМАУ-ын прокурор, түүний харьяа прокурорууд хяналт тавих, хяналт тавихдаа хуулийг аливаа хэлбэрээр зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, зөрчил гарсан тохиолдолд түүнийг хэн гаргасныг харгалзахгүйгээр арилгах арга хэмжээг цаг тухайд нь авч, буруутай этгээдийг хариуцлагад татах зэргийг тусгайлан заасан.

Тухайн хуульд хоригдлын эрхийн тогтолцоо илүү өргөжсөн бөгөөд садан төрлийн буюу бусад хүмүүстэй гурав хоног хүртэл удаан хугацаагаар уулзах; мөнгөн гуйвуулга хийх, хүлээн авах зэрэг эрхийг хуульчилснаас гадна хоригдолд хууль зүйн тусалцаа авах эрх эрх олгосон нь тэдний эрхийг хамгаалахад тэмдэглэхүйц үйл явдал болсон юм.

Гуравдугаар үе шат. Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрхийн талаар шинэ чиг хандлага тусгагдсан. Монголын ард түмэн бид хүний эрх, эрх чөлөөг дээдлэхийг эрхэм зорилго болгоно гэж заасан. Харин төрийн үүрэг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах болсон. Хорих ял эдлүүлэх хууль тогтоомжийн хувьд 1996 онд хуульд Засан хүмүүжүүлэх ажлын гэх нэр томъёог Шүүхийн шийдвэр биелүүлэх гэж өөрчлөн ухагдахууны хувьд хоригдлыг хөдөлмөрөөр дамжуулан хүмүүжүүлэхээс тэдний эрхийг хангах талруу болж өөрчлөгдсөн гэж үзэж болохоор байна.

1993 оны Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль нь²¹ хоригдлын эрхийн хүрээг илүү тэлсэн хууль болсон юм. Тухайлбал, тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн хувцас байраар хангагдах, эмнэлгийн тусламж авах; ойрын садан болон бусад хүнтэй түр, ойрын садантайгаа удаан хугацаагаар уулзах, захидлаар харилцах, эргэлт, илгээмж авах, өөрийн нэр дээр мөнгөн гуйвуулга авах, явуулах; холбогдох зардлаа өөрөө хариуцаж шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих зэрэг эрхүүдийг хуульчилсан байна.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хоригдолд шүүхээс оногдуулсан ял эдлэх нөхцөл, журам болон өөрийнхөө эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах; урьд тогтоосон өндөр насны болон бусад тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах; хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах зэрэг эрхийг олгосон байдаг²².

Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийг энэрэнгүй ёс, олон улсын стандартад нийцүүлэх ажил үйл явц үүгээр зогсоогүй бөгөөд 2017 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай шинэчлэн батлагдсан байна. Тус хуульд өөрөө зөвшөөрсөн эсэхээс үл хамааран эрүүл мэндэд нь эрсдэл учруулж болзошгүй аливаа туршилтаас ангид байх эрхийг хуульчилж өгсөн нь хорих ял эдлүүлэх нөхцөлд аливаа туршилтаас ангид байх баталгаа болсон юм.

²¹ А.Лхагва Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эрх сурвалж, УБ., 2013. 119-141 дахь тал.

²² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. № 8.